



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/208

Арвайхээр


┌ Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ┐  
тухай

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2020 оны 95, 110 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Уянга сумын 2 дугаар, Хужирт сумын 3 дугаар цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэл тус бүр 5 жилийн хугацаатай олгосугай.

2.Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон дээрх байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100457